



**БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ХАРГАЛЗАХ  
ХҮЧИН ЗҮЙЛ**

*Боловсруулсан: ХШГ, БӨБХ-ийн ахлах хянан шалгагч Б.Оюунцацрал*

*Энэ судалгаанд дурдагдсан аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн зохиогчийн хувийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны байр суурийг заавал илэрхийлэх албагүй болно.*

## ОРШИЛ

Аливаа банкны үйл ажиллагааны анхдагч эх үүсвэр болох хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний зохистой түвшин, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхэд харгалзах хүчин зүйл, эерэг болон сөрөг үр дагавар, өөрийн орны болон бусад орны банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг харьцуулан энэхүү судалгааг хийсэн болно.

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг банкны үйл ажиллагааны төрөл, чиглэл, онцлогтой уялдуулан тогтоодог бөгөөд банк алдагдал хүлээх тохиолдолд алдагдлын тодорхой хэсгийг нөхөх гол үүрэгтэй байдаг. Түүнээс гадна дараах хэд хэдэн үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлж, тэдгээрийн хөрөнгийн тодорхой хэсгийг хамгаалах.
2. Банкны урт хугацаат эх үүсвэр болдог бөгөөд банкны өсөлтийг хангах,
3. Банк харилцагчаас мөнгөн хөрөнгө татаагүй үед банкны үйл ажиллагаа явуулах үндсэн эх үүсвэр болдог,
4. Эрх бүхий хяналт шалгалтын болон зохицуулагч байгууллагын зүгээс банкны үйл ажиллагааг хянах гол хэрэгсэл болдог.

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн зохистой хэмжээ нь улс орны санхүү, банкны тогтолцооны найдвартай, хэвийн байдлыг хангахад гол нөлөө үзүүлдэг бөгөөд банкны үйл ажиллагааны алдагдлыг шингээж чадахуйц хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байснаар банкны актив хөрөнгө буурч, чанаргүй болох үед банкиг төлбөрийн чадваргүй болохоос тодорхой хэмжээгээр урьдчилан сэргийлж чаддаг. Сүүлийн жилүүдэд гарсан эдийн засгийн хямралаас улбаалан банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ их байх тусам банкны өөрийн хөрөнгийн хөшүүргийн харьцаа нэмэгдэж системийн тогтвортой байдалд эергээр нөлөөлдөг хэмээн зарим судлаачид үзсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгө их байх тусам банкны салбарын тогтвортой байдал нэмэгдэнэ гэж үздэг зарим хэсэг байхад банкны эзэд, хувьцаа эзэмшигч нар хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, өөрийн хөрөнгийн хөшүүргийн харьцааг өндрөөр тогтоох нь хэт өндөр зардалтай, банкны ашиг олох боломжийг бууруулдаг гэж үздэг. Банк, санхүүгийн байгууллагууд бие биенийхээ үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай болсон өнөө үед томоохон банк төлбөрийн чадваргүй болоход бусад банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж, улмаар санхүү, эдийн засгийн хямралыг үүсгэхэд нөлөөлж байна. Эдийн засгийн хямралын үед банк, санхүүгийн системийг тогтворжуулахад төрөөс тодорхой хэмжээний зардал гаргаж, хохирлыг бууруулах арга хэмжээ авдаг тул банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өндөр байлгах нь банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэн эдийн засагт гарах сөрөг үр дагавараас сэргийлнэ.

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн зохистой хэмжээг тогтоох нэгдсэн аргачлал байдаггүй ч тогтоосон хэмжээ нь банкны тогтвортой, найдвартай ажиллагааг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигч нарын эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж улмаар улс орны эдийн засгийг хөгжил, тогтвортой байлгаж, хөгжихөд нөлөөлөх боломжтой болно. Иймд банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг банкны үйл ажиллагааны төрөлжилт, үндсэн үйл ажиллагааны өсөлт зэрэгтэй уялдуулан тухай бүр, оновчтой өөрчилж байх нь банкны салбар дахь санхүүгийн сахилга батыг сайжруулах сайн талтай юм.

### **Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд харгалзах хүчин зүйлс**

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд дараах хүчин зүйлсийг ихэвчлэн харгалзан үздэг. Үүнд:

1. Макро эдийн засгийн нөхцөл байдал Макро эдийн засгийн байдал тогтвортой байх тусам банкны хүлээж болзошгүй ерөнхий эрсдэлийн түвшин бага байдаг бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага бага байдаг.
2. Зах зээлийн эрэлт хэрэгцээ Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлага болон банкны үйл ажиллагааны цар хүрээг тэлэх шаардлагатай эсэхэд үндэслэн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж болдог.
3. Олон улсын хяналт, зохицуулалтын стандартыг хангах (Базелийн хорооноос тогтоосон өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах гэх мэт) зорилгоор хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх.

Олон улсын туршлагаас харахад банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн банкны активын 3-4 хувийг эзэлж байхад хангалттай гэж үздэг бөгөөд харин энэ харьцаа 2 хувиас доош байвал банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үздэг.

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хяналт шалгалтын байгууллагаас нэмэгдүүлэхэд дараах эерэг болон сөрөг талууд гардаг. Тухайлбал:

1. Ойрхон хугацааны давтамжтайгаар хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлэх нь банкны бизнес төлөвлөгөөг өөрчлөх, тогтвортой өсөлтөнд сөргөөр нөлөөлөх, эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх магадлалыг нэмэгдүүлж болзошгүй байдаг.
2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхэд жижиг хэмжээтэй банкууд шахагдах магадлалтай байдаг бөгөөд цөөн тооны том банк зах

зээлд үйл ажиллагаа явуулснаар банкны өрсөлдөөн хязгаарлагдмал болж, санхүүгийн үйлчилгээний хүртээмж буурах талтай. Түүнчлэн тухайн нэг банкны зах зээлд эзлэх хувь хэмжээ нэмэгдсэнээр төлбөрийн чадваргүй болж, татан буугдахад системд хэт өндөр эрсдэл учруулах (too big to fail) банкны тоо нэмэгдэж болзошгүй. Төлбөрийн чадваргүй болж, дампуурахад хэтэрхий эрсдэлтэй банкиг төрөөс хамгаалах, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг жишиг түгээмэл байдаг учир ёс зүйн гажуудлыг бий болгох (moral hazard), улмаар банк, санхүүгийн системийн эрсдэлтэй, тогтворгүй байдлыг бий болгоход нөлөөлдөг.

3. Банкуудын үйл ажиллагааны цар хүрээ өргөжих, хөрөнгийн хэмжээ нэмэгдэх боломжтой болох бөгөөд томоохон төслүүдийг дангаараа санхүүжүүлэх, нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ нэмэгдэх боломжтой болдог.
4. Зах зээл дэх банкны тоо буурч, томоохон банкууд бий болж, тэдгээр нь зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах нөхцөл бүрдэж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэйгээр хүргэж чадаж байвал банкны ашиг нэмэгдэх, улмаар эрсдэл багатай үйл ажиллагаа явуулах, эрсдэл даах чадвар нэмэгдэх, алдагдал хүлээсэн ч түүнийг нөхөх хэмжээний хөрөнгөтэй байж чаддаг учир зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын боловсронгуй тогтолцоотой цөөн тооны томоохон банкууд байх нь зохистой байх боломжтой юм.

### *Монголын банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн байдал*

Хоёр шатлалт банкны систем үүссэн үе буюу 1991 онд Банкны тухай хууль батлагдах үед банкны дүрмийн сангийн хэмжээ анх 50.0 сая төгрөг байсан бөгөөд түүнээс хойш 1995 онд 400.0 сая төгрөг, 1999 онд 2.0 тэрбум төгрөг, 2001 онд 4 тэрбум төгрөг, 2006 онд 8.0 тэрбум төгрөг, 2011 онд 16.0 тэрбум төгрөг байхаар тогтоож байсан.

Одоогийн байдлаар банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:

**2014.5.30-ны байдлаар (тэрбум төгрөг)**

ДД	Банкны нэр	Нийт актив	Системийн нийт активт эзлэх хувь (%)	Эзэмшигч-дийн өмч	Хувь нийлүүлсэн хөрөнгө	ХНХ-ийн активт эзлэх хувь (%)	Ашиг, алдагдал	
							Тухайн жилийн	Хуримтлагдсан
1	Худалдаа хөгжлийн Банк	5,142.0	26.0	476.5	35.8	0.7	38.4	299.3
2	ХААН банк	4,762.6	24.1	572.1	47.1	1.0	32.8	296.1
3	Голомт банк	3,659.9	18.6	345.4	85.8	2.3	12.4	173.4
4	Төрийн банк	1,896.3	9.6	144.8	113.0	6.0	12.6	5.4
5	Хас банк	1,881.8	9.6	221.9	55.3	3.0	9.2	56.3
6	Улаанбаатар хотын банк	1,193.5	6.0	66.7	16.0	1.3	10.3	26.7
7	Капитал банк	621.0	3.1	43.3	36.8	6.0	1.8	3.6
8	Чингис хаан банк	202.9	1.0	13.0	39.4	19.4	-7.5	-18.9
9	Капитрон банк	196.4	1.0	15.4	16.0	8.1	-5.7	-0.1
10	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	120.5	0.6	10.5	16.4	13.6	-3.9	-1.9
11	Эрэл банк	56.0	0.3	15.6	16.3	29.1	-1.7	1.0
12	Кредит банк	12.3	0.06	12.0	16.1	130.9	0.1	-4.2
13	Тээвэр хөгжлийн банк	11.5	0.05	11.3	16.0	139.1	1.0	-5.7
	<b>Нийт дүн</b>	<b>19,756.7</b>	<b>100.0</b>	<b>1,948.5</b>	<b>510.0</b>	<b>2.6</b>	<b>99.8</b>	<b>831.1</b>

Арилжааны 13 банкны нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 2014 оны 5 дугаар сарын байдлаар 1,948.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд нийт системийн актив хөрөнгийн 9.9 хувийг эзэлж байна. Харин 4 банкны хувьд 3 хувиас доогуур үзүүлэлттэй байна. Нийт 6 банк (Эрэл, Улаанбаатар хотын, Капитрон, Үндэсний хөрөнгө оруулалтын, Кредит, Тээвэр хөгжлийн банк)-ны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 16.0 тэрбум төгрөг байгаа бол бусад банк нь 35.7-113.0 тэрбум төгрөг байна. Банкууд хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзвэл хамгийн багадаа 30.0-40.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой нь харагдаж байна.

***Бусад орны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бусад орны туршилага***

Улс орны санхүүгийн хяналтын эрх бүхий байгууллагууд бүр өөрийн онцлог байдал, эдийн засаг, хууль эрх зүйн нөхцөл байдлаас шалтгаалан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг ялгаатайгаар тогтоодог. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох нэгдсэн аргачлал гэж байдаггүй боловч ерөнхий баримталдаг зарчим нь гадаадын банк, охин компани, салбар, гадаадын

хөрөнгө оруулалтай банк, дотоодын банкны төрөл, онцлог, цар хүрээнээс хамааран харилцан адилгүйгээр тогтоодог жишиг тогтсон байна. Нийтлэг үйл ажиллагаатай банкинд хамгийн их хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг төрөлжсөн банк, орон нутгийн банкуудаас илүү өндрөөр тогтоож болдог. Тухайлбал: ОХУ-д банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 300.0 сая рубль бөгөөд эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааран 180 сая, 90 сая, 18 сая рубль байдаг. БНХАУ-ын хувьд төрийн өмчийн оролцоотой банк, 2-р зэрэглэлийн банк, хотын болон орон нутгийн банк зэрэг банкууд байдаг бөгөөд банкны хэмжээнээс хамааран хувь нийлүүлсэн хөрөнгө нь 1 тэрбум юань, 100 сая юань, 50 сая юань байдаг байна. Бусад орнуудтай харьцуулахад азийн орнууд хамгийн өндөр шаардлага тавьдаг бөгөөд үүнд Сингапур, Малайз, Индонез, Тайван зэрэг орнууд орсон. Сингапурт дотоодын банк болон гадаадын банкны охин компанид хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 1,200.0 сая ам.доллар, гадаадын банкны салбарт 153.0 сая ам.доллараар тогтоодог. Малайзид арилжааны банкинд 400.0 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын банкинд 135.0 сая ам.доллар, Индонезид арилжааны банкинд 300.0 сая ам.доллар, хөдөө орон нутгийн банкинд 50.0-500.0 мянган ам.доллараар тус тус тогтоодог байна.

ОХУ санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор 2015 оноос эхлэн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 300.0 сая рубль буюу 9.0 сая ам.доллар болгохоор 2011 онд шийдвэрлэсэн. Түүнчлэн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа банкуудад цаг хугацааны хувьд боломж олгож, аажмаар жижиг банкуудын тоог цөөлөх бодлого барьж байна. АНУ-ын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг мужийн эрх бүхий байгууллага тогтоодог бөгөөд хөдөө орон нутагт үйлчлэх банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 25.0 мянган доллараас эхэлдэг. Дунджаар хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 1985 онд 1.5 сая ам.доллар, 1990 онд 4.0 сая ам.доллар, 2005 онд 5 сая ам.доллар байсан байна. Түүнчлэн суурин газрын онцлогоос шалтгаалан тогтоох боломжтой бөгөөд тухайлбал: Чикаго хотод нийтлэг хэлбэрийн арилжааны банкинд 5.0 сая ам.доллар, хотын ойр орчимд байрлах банкинд 3-2.5 сая ам.доллар байдаг бол Нью Йоркт 2.0 сая ам.доллар байдаг байна. Хуучин Зөвлөлт холбоот улсын харьяанд байсан болон Балтын Тэнгисийн улсуудын хувьд дунджаар 10.0 сая ам.доллар байгаа бөгөөд хамгийн өндөр шаардлагатай улсад Казахстан 30.0 сая ам.доллараар тогтоосон байна. Казахстан улс 2011 онд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн бөгөөд банкны актив хөрөнгийн өсөлттэй холбоотойгоор нэмсэн байна.

2013 оны байдлаар

Улс орон	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ (сая ам.доллар)	Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Банкны тоо	100,000 хүн ам тутамд ногдох банкны тоо	Нийт хүн ам (сая хүн)	ДНБ (тэрбум ам.доллар)	Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)
Монгол	9.64	12% <sup>1</sup> 14% <sup>2</sup>	13	0.45	2.8	10.3	4,056
Хятад	165.1 16.5 8.2	8.5% <sup>1</sup> 9.5% <sup>2</sup>	409	0.03	1,350.7	8,229.5	6,807
Орос	9.1 5.5 2.7	7.5%	923	0.64	143.2	2,017.5	14,611
Солонгос	94.5	8%	56	0.11	50.2	1,222.8	25,977
Албани	5.0	12%	16	0.57	2.8	12.3	4,652
Чех	25.1	12%	23	0.22	10.5	196.5	18,861
Унгар	9.27	4%	42	0.42	9.9	124.6	12,560
Казакстан	30.0	12%	38	0.22	17.0	203.5	13,172
Киргизстан	4.1		24	0.42	5.7	6.6	1,263
Узбекистан	6.8		27	0.09	30.2	51.2	1,878

Эх сурвалж: Дэлхийн банкны дата өгөгдлийн систем [www.data.worldbank.org](http://www.data.worldbank.org)

<sup>1</sup> системийн ач холбогдол бүхий банкнаас бусад банк

<sup>2</sup> системийн ач холбогдол бүхий банк

Хэдийгээр улс орнуудын хувьд банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтооход харгалзах хүчин зүйл харилцан адилгүй байдаг ч зарим судлаачдын хийсэн судалгааны дүнгээс харахад:

1. Дотоод болон гадаадын банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг ялгавартайгаар тогтоох,
2. Банкны төрөл, үйл ажиллагааны онцлог, хэмжээнээс хамааран ялгавартай тогтоодог нийтлэг туршлага ажиглагдаж байна.

Ерөнхийдөө улс орнуудын банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэг түвшинд ойртох явдал ажиглагдаж байна. Тухайлбал: Европын холбооны улсуудын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 5.0 сая евро гэж тогтоосныг харгалзан дэлхийн ихэнх орнууд банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 1-5 сая еврогоор тогтоож байна.

## САНАЛ, ДҮГНЭЛТ

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх нь макро эдийн засгийн тогтвортой байдал, зах зээлийн эрэлт хэрэгцээ, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг хангах зэрэг зорилготой байдаг. Манай улсын банкны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргахад дээрх хүчин зүйлүүдээс гадна дараах саналуудыг харгалзан үзэх нь зүйтэй байна. Үүнд:

### 1. Макро эдийн засгийн хүчин зүйл

Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөлд (ДНБ-ний өсөлт 2014 оны эхний улирлын байдлаар 7.4%, инфляци 2014 оны 5-р сарын байдлаар 13.7%, ажилгүйдлийн түвшин 2014 оны эхний улирлын байдлаар 9.4%) банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай эсэх, зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа банкны тоо зохистой эсэх, банкны тоог бууруулах шаардлагатай эсэхийг уг судалгаагаар дүгнэхийг зорилоо.

Банкны өрсөлдөөн болон системийн тогтвортой байдлын харилцан хамаарлыг судалсан судлаачдын дүгнэлтээс харахад санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэж чадаж байгаа, тархмал багцтай цөөн тооны томоохон банкууд зах зээлд байх нь олон жижиг банк байснаас санхүүгийн тогтвортой байдалд эергээр нөлөөлдөг гэж үздэг. Олон жижиг банк нь өрсөлдөөнийг бий болгож, хүүгийн түвшинг бууруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, шинэ технологи бий болгох, санхүүгийн зуучлалын зардлыг багасгах давуу талтай ч зах зээлд гадаадын банкны эзэмшил байхгүй, харилцагчдын мөнгөн хөрөнгө хадгаламжийн даатгалаар бүрэн хамгаалагдсан, банкны үйл ажиллагааг хязгаарладаггүй манай орны хувьд зах зээлд бага хувь эзлэх жижиг банк олон байх нь шудрага бус өрсөлдөөнийг бий болгох, хадгаламжийн хүүг өсгөх, улмаар санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг зардал багатайгаар нэмэгдүүлэх үүднээс банкуудын хуримтлуулсан ашгийн тодорхой хэсгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэх боломжтой. Энэ тохиолдолд Худалдаа хөгжлийн банк, ХААН, Голомт, Хас, Улаанбаатар хотын банк 26.7-299.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж болох бөгөөд харин жижиг буюу дунд банкууд хуримтлуулсан ашгаар хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх боломжгүй байна. Монголбанкнаас хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон тохиолдолд дунд болон жижиг банкууд хуримтлуулсан ашгаас өөр эх үүсвэрээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай болж байна. Энэ нь тодорхойгүй эсвэл зардал ихтэй эх үүсвэрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хязгаарлагдмал сонголтыг банкуудад бий болгох сөрөг талтай.



## 2. Зах зээлийн эрэлт хэрэгцээ

Дэлхийн банкнаас 2012 онд хийсэн судалгаагаар манай орны нийт хүн амын 78 хувь нь харилцах данстай, 42 хувь нь зээлийн үйлчилгээ хүртсэн тооцоо гарчээ. 2013 оны 5-р сарын байдлаар системийн нөлөө бүхий 6 банкны (ХААН, Хас, Голомт, Худалдаа хөгжил, Улаанбаатар хотын, Төрийн банк) харилцагчдын тоо нийт харилцагчдын 95%, хадгаламж эзэмшигчдийн тоо 98%, зээлдэгчдийн тоо 96%-ийг тус тус эзэлж байна. Үүнээс үзэхэд системийн нөлөө бүхий банкууд санхүүгийн зах зээлийн эрэлт хэрэгцээг ханган ажиллаж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэйгээр хүргэж байна гэж дүгнэж болохоор байна. Иймд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлснээр зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа жижиг банкуудыг нэгтгэх, өөрчлөн байгуулалт, бүтцийн өөрчлөлт хийх зэргээр тоог цөөрүүлэх боломжтой.

## 3. Олон улсын стандартыг хангах

Базел 3 стандартын шаардлагын дагуу банкны энгийн хувьцаа, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 2014 онд 4.0 хувь, 2015 оноос эхлэн 4.5 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 5.5 хувь, 2015 оноос 6.0 хувь, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 8 хувь байхаар тогтоосон. Харин Монголын арилжааны банкуудын хувьд 2014 оны 5-р сарын байдлаар банкны системийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 16.5%, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 11.9% байгаа нь Базелийн хорооноос тогтоосон болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааг бүрэн хангаж байгаа учраас энэ зорилгоор хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагагүй байна.

*Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банкуудын өрсөлдөөнийг чанаржуулах, банкуудын үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ макро эдийн засгийн нөхцөл байдал, зах зээлийн хэрэгцээ, санхүүгийн салбарын онцлог зэрэг хүчин зүйлээс гадна тухайн банкны үйл ажиллагааны цар хүрээ, хэмжээ, системд үзүүлж байгаа нөлөө, эрсдэлийн түвшин зэргээс шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалттай банк, гадаадын банк, системийн нөлөө бүхий банк, жижиг дунд банкуудын хувьд ялгавартай тогтоох нь зохистой гэж үзлээ.*

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ:**

Schaeck, K., Cihak, M., Wolfe, S. “Are more competitive banking systems more stable?” *Journal of Money, Credit and Banking*, 2009.

Maria-Eleni Agoraki and Manthos D Delis and Fotios Pasiouras “Regulations, competition and bank risk-taking in transition countries” MPRA Paper No. 16495, posted 30 July 2009.

Deniz Anginer, Asli Demirguc-Kunt, Min Zhu “How Does Bank Competition Affect Systemic Stability?” *Policy Research Working Paper* 5981, 2012.

Lev Ratnovski “How much capital should banks have” [www.voxeu.org](http://www.voxeu.org), 2013.

Douglas J.Elliott “Higher bank capital requirements would come at a price” [www.brookings.edu](http://www.brookings.edu), 2013.

Anat R. Admati, Peter M. DeMarzo, Martin F. Hellwig, Paul Pfleiderer “Fallacies, Irrelevant Facts, and Myths in the Discussion of Capital Regulation: Why Bank Equity is Not Socially Expensive”, October 22, 2013

Simon Jonhson “Higher Bank Equity Is in the Public Interest” [www.bloombergview.com](http://www.bloombergview.com), March 3, 2013

Douglas W. Diamond Raghuram G. Rajan “A theory of bank capital” *NBER Working paper series*, 1999

С.Моисеев “Международная практика регулирования капитала банка” *Экономическое развитие России* №4, 2010

Монгол улсын статистикийн үндэсний хороо, [www.nso.mn](http://www.nso.mn)

World bank, [www.data.worldbank.org](http://www.data.worldbank.org)